

Германд 200 мянга гаруй хүн оролцсон эсэргүүцлийн жагсаал цуглаан болжээ

Тоймлож орчуулсан Амарлин

2011 оны 3 сарын 26. Германы дөрвөн хотод цөмийн реакторуудын үйл ажиллагааг зогсоож, хаахыг шаардсан 210-250 мянга гаруй хүн жагсчээ. Берлин, Хамбург, Колон, Мюнхен хотуудад байгаль орчны байгууллагуудын зохион байгуулсан тус үйл ажиллагааг сөрөг хүчний Германы Социал Демократ нам, Ногооны болон Зүүний нам, протестант, католик сүмүүд, Германы үйлдвэрчний эвлэлүүдийн эвсэл болон "Wir sind Helden" хамтлаг дэмжсэн байна.



Берлинд зохион байгуулсан эсэргүүцлийн жагсаалд 50 мянган хүн ирэхээр тооцоолж байсан ч Байгаль Орчныг Хамгаалах байгууллагын мэдээлснээр тооцоолсноос 2 дахин олон буюу 90-120 гаруй мянган хүн оролцжээ. Хамбург хотод 50 мянга, Колонд 40 мянга, Мюнхенд 30-40 мянга гаруй хүн жагссаны дотор Герман улсын цөмийн шинжээч Торстен Бекер байсан байна. Тус жагсаал нь Японы цөмийн реакторуудад гарсан ослын шууд үр дүн бөгөөд хэдэн зуун мянган Герман иргэд Японд болсон явдалд сэтгэл түгшиж буй болон цөмийн осолд хохирсон Японы ард түмэнтэй эв нэгдэлтэй буйгаа илэрхийлэхийг хүсчээ.



Фукушимагийн цөмийн станцад аюултай байдал үүссэний дараахан Германы канцлер Анжела Меркел өөрийн улсын цөмийн реакторуудын ашиглалтын хугацааг сунгахыг 3 сараар хойшлуулж, хамгийн олон жилийн настай 7 реакторын үйл ажиллагааг аюулгүйн шалгалт хийгдтэл түр зогсоосон билээ. Гэвч олон нийтийн жагсаал цуглаан болохоос хэдхэн хоногийн өмнө Германы Санхүү Эдийн Засгийн сайд Райнер Брюдер нь эдгээр арга хэмжээг удахгүй болох орон нутгийн сонгуулийн өмнөх тоглолт хэмээн мэдэгдсэн байна.



Германы засгийн газрын бодлогыг шүүмжилсэн уриа лозунг барьсан жагсагчдын дунд нийгмийн болон улс төрийн олон давхарга, бүлгийн төлөөлөгчид байсан ч тэд бүгд цөмийн эрчим хүчийг бүх хэлбэрийг нэн даруй хориглох тухай нэгдмэл шаардлага тавьж байсан юм. Жагсаалд оролцогчид Германы эвслийн засгийн газарт хандаж, эрчим хүчний салбарыг эрс шинэчлэхийг шаардаж, “ухаараач, бодлогоо эргэж хараач” гэж уриалж байв.



Германы Социал Демократ Намын тэргүүн Сигмар Габриел Берлинд жагсаалд амжилттай болж олон нийт өргөнөөр оролцсонд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд, “энэ бол Германчууд цөмийн эрчим хүч үйлдвэрлэлийг эсэргүүцэж буйн бодит илэрхийлэл боллоо” гэв.



Жагсаал болсны маргааш Германы Rhineland-Palatinat болон Baden-Württemberg мужуудын засаг захиргааны сонгууль болоход Ногоон намынхан дээгүүр санал авчээ.

Ашигласан материал:

1. Германы өдөр тутмын “Rheinische Post” сонины 3 сарын 28 дугаар Цахим сурвалж: http://www.rp-online.de/politik/deutschland/Ueber-200000-Menschen-auf-der-Strasse_aid_980274.html

2. World Socialist цахим хуудас
Стефан Стэйнберг “Германд цөмийн эрчим хүч ашиглахыг эсэргүүцсэн олон нийтийн жагсаал боллоо” 28 March 2011 нийтлэгдсэн
Цахим хаяг: <http://www.wsws.org/articles/2011/mar2011/gdem-m28.shtml>

3. Германы өдөр тутмын “International –Spiegel ONLINE” цахим сонин
Роланд Неллс “Ням гаригт болсон сонгуулиас Канцлер Меркел ямар сургамж авав”
2011 оны 3 сарын 28 нийтлэгдсэн
Цахим хаяг: <http://www.spiegel.de/international/germany/0,1518,753542,00.html>